



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/211-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН РАШААНТ
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.БҮРЭНЦОГТ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/211-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 91.1 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь сургалт семинарын зардлыг 286.0 мянган төгрөгөөр, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 1,273.2 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 4,103.3 мянган төгрөгөөр, хүүхдэд ээлтэй сургалтын орчин хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 132.1 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 52,937.4 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн зардлыг 3,785.4 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсвийг 8.9 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 9 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,984,135.36	106,536,721.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,474,840.75	62,520,726.42
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	34,474,840.75	62,520,726.42
31210	Төгрөг	34,474,840.75	62,520,726.42
31211	Төрийн сангийн харилцах	34,474,840.75	62,520,726.42
33	АВЛАГА	1,864,392.01	1,864,392.01
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	50,000.00	50,000.00
33500	Бусад авлага	1,814,392.01	1,814,392.01
33510	Байгууллагаас авах авлага	1,348,000.01	1,348,000.01
33520	Хувь хүмүүсээс авах авлага	466,392.00	466,392.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,644,902.60	42,151,602.90
35100	Түүхий эд материал	-	112,120.00
35130	Эм боох материал	-	112,120.00
35400	Хангамжийн материал	32,644,902.60	42,039,482.90
35410	Бичиг хэргийн материал	5,415,396.54	7,612,956.84
35420	Аж ахуйн материал	23,696,566.06	29,360,246.06
35460	Хүнсний материал	3,263,500.00	4,796,840.00
35470	Бусад хангамжийн материал	269,440.00	269,440.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	953,190,143.86	950,956,662.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	953,190,143.86	950,956,662.55
39200	Биет хөрөнгө	890,592,743.82	888,984,262.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	884,329,874.00	904,329,874.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(117,299,684.53)	(148,125,042.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,285,775.72)	(13,885,775.68)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	144,995,655.50	169,108,415.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,162,932.02)	(97,034,657.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,348,284.40	93,732,744.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,479,436.18)	(53,698,022.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,506,217.64	10,506,217.64
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,000,000.00)	(3,000,000.00)
39217	Ном	8,640,540.73	11,050,509.23
39300	Биет бус хөрөнгө	62,597,400.04	61,972,400.08
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(874,999.96)	(1,499,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	61,972,400.00	61,972,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,022,174,279.22	1,057,493,383.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,022,174,279.22	1,057,493,383.88
51	Засгийн газрын хувь оролцоо	1,022,174,279.22	1,057,493,383.88
51100	Засгийн газрын оруулсан капитал	275,443,955.60	275,443,955.60
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	275,443,955.60	275,443,955.60
51200	Хуримтлагдсан үр дүн	(26,797,880.99)	8,521,223.67
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,047,536,781.70)	(26,797,880.99)
51220	Тайлант үеийн үр дүн	1,020,738,900.71	35,319,104.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	773,528,204.61	773,528,204.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,022,174,279.22	1,057,493,383.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,867,726,873.78	1,025,660,435.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,025,864,788.39	46,294,476.80
120	Нийтлэг татварын бус орлого	1,025,864,788.39	46,294,476.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,511,000.00	3,291,148.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,511,000.00	1,793,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,497,648.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	992,818,285.79	35,142,088.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	31,535,502.60	7,861,240.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	841,862,085.39	979,365,958.57
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	692,439,300.00	843,071,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	692,439,300.00	843,071,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	149,422,785.39	136,294,458.57
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	149,422,785.39	136,294,458.57
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	846,987,973.07	990,341,330.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	846,987,973.07	990,341,330.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	813,691,825.31	955,097,289.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,428,247.00	644,092,396.00
210101	Үндсэн цалин	386,625,544.00	456,930,487.00
210102	Нэмэгдэл	128,138,400.00	169,848,373.00
210104	Урамшуулал	11,664,303.00	17,313,536.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,753,908.92	81,888,596.77
210201	Тэтгэврийн даатгал	46,513,116.78	56,153,656.77
210202	Тэтгэмжийн даатгал	5,409,714.32	6,574,698.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,270,651.43	5,198,158.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,050,947.48	1,268,713.88
210205	Эрүүл мэндийн даатгал	10,509,478.91	12,693,369.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,244,901.39	131,402,578.57
210301	Гэрэл, цахилгаан	5,259,171.39	7,178,738.01
210302	Түлш, халаалт	108,875,733.33	114,319,520.00
210303	Цэвэр, бохир ус	17,109,996.67	9,904,320.56
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,846,430.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,846,430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,713,480.00
210604	Урсгал засвар	-	4,713,480.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,383,000.00	7,351,499.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,511,000.00	1,793,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,872,000.00	5,557,999.06
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,881,768.00	83,802,308.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,869,126.00	14,884,639.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,435,900.00	7,777,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,576,742.00	61,140,669.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,296,147.76	35,244,041.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,296,147.76	35,244,041.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,296,147.76	35,244,041.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,020,738,900.71	35,319,104.66
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,020,738,900.71	35,319,104.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	843,373,085.39	982,657,106.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,511,000.00	3,291,148.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,511,000.00	3,291,148.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,511,000.00	3,291,148.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,511,000.00	1,793,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,497,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	841,862,085.39	979,365,958.57
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	692,439,300.00	843,071,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	692,439,300.00	843,071,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	149,422,785.39	136,294,458.57
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	149,422,785.39	136,294,458.57
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	787,949,644.64	930,846,120.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	787,949,644.64	930,846,120.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	753,669,596.88	894,068,739.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,428,247.00	644,092,396.00
210101	Үндсэн цалин	386,625,544.00	456,930,487.00
210102	Нэмэгдэл	128,138,400.00	169,848,373.00
210104	Урамшуулал	11,664,303.00	17,313,536.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,182,922.49	81,888,596.77
210201	Тэтгэврийн даатгал	46,942,130.35	56,153,656.77
210202	Тэтгэмжийн даатгал	5,409,714.32	6,574,698.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,270,651.43	5,198,158.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,050,947.48	1,268,713.88
210205	Эрүүл мэндийн даатгал	10,509,478.91	12,693,369.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,244,901.39	131,402,578.57
210301	Гэрэл, цахилгаан	5,259,171.39	7,178,738.01
210302	Түлш, халаалт	108,875,733.33	114,319,520.00
210303	Цэвэр, бохир ус	17,109,996.67	9,904,320.56
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	445,500.00	4,891,880.00
210604	Урсгал засвар	445,500.00	4,891,880.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,383,000.00	7,351,499.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,511,000.00	1,793,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,872,000.00	5,557,999.06
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,985,026.00	24,441,789.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,432,626.00	16,524,789.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,552,400.00	7,917,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,280,047.76	36,777,381.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,280,047.76	36,777,381.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,280,047.76	36,777,381.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	55,423,440.75	51,810,985.67
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	20,948,600.00	23,765,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,948,600.00	23,765,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,948,600.00	23,765,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,948,600.00	23,765,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(20,948,600.00)	(23,765,100.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	34,474,840.75	28,045,885.67
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	34,474,840.75
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,474,840.75	62,520,726.42

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	275,443,955.60	773,528,204.61	(1,047,536,781.70)	1,435,378.51
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	(1,047,536,781.70)	1,435,378.51
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,020,738,900.71	1,020,738,900.71
10	2022 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	(26,797,880.99)	1,022,174,279.22
11	2023 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	(26,797,880.99)	1,022,174,279.22
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	(26,797,880.99)	1,022,174,279.22
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	35,319,104.66	35,319,104.66
20	2023 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	8,521,223.67	1,057,493,383.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,048,258,000.00	954,611,220.90	93,646,779.10	91.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,048,258,000.00	954,611,220.90	93,646,779.10	91.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,007,377,400.00	917,833,839.40	89,543,560.60	91.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	695,736,200.00	644,092,396.00	51,643,804.00	92.6
210101	Үндсэн цалин	465,438,100.00	456,930,487.00	8,507,613.00	98.2
210102	Нэмэгдэл	207,351,200.00	169,848,373.00	37,502,827.00	81.9
210104	Урамшуулал	22,946,900.00	17,313,536.00	5,633,364.00	75.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,967,200.00	81,888,596.77	5,078,603.23	94.2
210201	Тэтгэврийн даатгал	59,137,600.00	56,153,656.77	2,983,943.23	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,957,400.00	6,574,698.05	382,701.95	94.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,565,900.00	5,198,158.23	367,741.77	93.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,391,500.00	1,268,713.88	122,786.12	91.2
210205	Эрүүл мэндийн даатгал	13,914,800.00	12,693,369.84	1,221,430.16	91.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,527,900.00	131,402,578.57	29,125,321.43	81.9
210301	Гэрэл, цахилгаан	10,323,900.00	7,178,738.01	3,145,161.99	69.5
210302	Түлш, халаалт	136,498,400.00	114,319,520.00	22,178,880.00	83.8
210303	Цэвэр, бохир ус	13,705,600.00	9,904,320.56	3,801,279.44	72.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,892,600.00	4,891,880.00	720.00	100.0
210604	Урсгал засвар	4,892,600.00	4,891,880.00	720.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,351,500.00	7,351,499.06	0.94	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,793,500.00	1,793,500.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,558,000.00	5,557,999.06	0.94	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,902,000.00	48,206,889.00	3,695,111.00	92.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,414,400.00	39,719,989.00	3,694,411.00	91.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,487,600.00	8,486,900.00	700.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,880,600.00	36,777,381.50	4,103,218.50	90.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,880,600.00	36,777,381.50	4,103,218.50	90.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,880,600.00	36,777,381.50	4,103,218.50	90.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,048,258,000.00	982,657,106.57	65,600,893.43	93.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	843,071,500.00	843,071,500.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	843,071,500.00	843,071,500.00	-	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	160,488,200.00	136,294,458.57	24,193,741.43	84.9
320001	Орон нутгийн төсвөөс	160,488,200.00	136,294,458.57	24,193,741.43	84.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	44,698,300.00	3,291,148.00	41,407,152.00	7.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,793,500.00	1,793,500.00	2,000,000.00	47.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,497,700.00	1,497,648.00	52.00	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	39,407,100.00	-	39,407,100.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	34,474,840.75	(34,474,840.75)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	62,520,726.42	(62,520,726.42)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь *“Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилсан менежментийг сайжруулж, хүүхэд бүрийн онцлогт нийцүүлэн сурах, хөгжих арга барилыг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зөв цэвэр тэмдэглэх чадварт суралцуулах, хөгжүүлэх,
- Бие даан сурах арга барилыг төлөвлөн эзэмшүүлэх,
- Өглөөний уншлагаар дамжуулан уншаад ойлгох чадварыг нэмэгдүүлэх,
- Эрүүл зөв дадал хэвшүүлэх,
- Бие биенийхээ ялгаатай байдлыг ойлгох хүндэтгэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1.“ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, 2.“Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт,*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,319.2 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	34,474.8	62,520.7	28,045.9
Авлага	1,864.4	1,864.4	-
Бараа материал	32,644.9	42,151.6	9,506.7
Үндсэн хөрөнгө	953,190.1	950,956.7	(2,233.4)
Нийт хөрөнгө	1,022,174.2	1,057,493.4	35,319.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,022,174.2	1,057,493.4	35,319.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,022,174.2	1,057,493.4	35,319.2

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 62,520.7 мянган төгрөг болж 28,045.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 42,151.6 мянган төгрөг болж 9,506.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 56,158.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн БШУГ-аас 7,861.2 мянган төгрөгийн сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үйл ажиллагаанд 54,512.8 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 950,956.7 мянган төгрөг болж 2,233.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 23,765.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Сэлэнгэ аймгийн БШУГ-аас 15,142.1 мянган төгрөгийн ном, сургалтын хэрэглэгдэхүүн, сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 20,000.0 мянган төгрөгийн хашааг үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,121,407.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 144,373.9 мянган төгрөг нийт 1,265,781.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 476,571.3 мянган төгрөгөөр бууруулж 644,836.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 4,892.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 149,266.5 мянган төгрөгөөр, нийт 794,102.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 238,001.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 882,837.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 16,154.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 165,420.5 мянган төгрөгөөр, нийт 1,048,258.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 882,837.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 165,420.5 мянган төгрөг, нийт 1,048,258.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 954,611.2 мянган төгрөгийг зарцуулж, 24,193.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 62,520.7 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 954,611.2 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь эрүүл мэндийг дэмжих зардлыг 1,273.2 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 4,103.3 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 52,937.4 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн зардлыг 3,785.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	882,837.5	818,316.8	64,520.7	92.7
80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	2,239.7	2,239.3	0.4	100.0
80312 - Сургалт семинар	1,212.4	926.4	286.0	76.4
81605 - Эрүүл мэндийг дэмжих	2,223.2	950.0	1,273.2	42.7
81801 - Үдийн цай хөтөлбөр	40,880.7	36,777.4	4,103.3	90.0
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	23,075.9	22,943.8	132.1	99.4
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	5,002.2	5,000.0	2.2	100.0
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	709,640.3	656,702.9	52,937.4	92.5
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	93,271.9	89,486.5	3,785.4	95.9
81848-Сурах бичгийн түрээс	3,793.5	1,793.5	2,000.0	47.3
83603- Дээд шатны төсвөөс	1,497.7	1,497.0	0.7	100.0

Орон нутгийн төсвөөс санхүүжих	165,420.5	136,294.4	29,126.1	82.4
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	165,420.5	136,294.4	29,126.1	82.4
ДҮН	1,048,258.0	954,611.2	93,646.8	91.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ сургуулийн үдийн цайнд 40,879.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 847,217.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,708.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр иргэн Наранчимэг, Хишигжаргал, болон “Замбалзоог” ХХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Их баян бургастай” ХХК - тай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 2: "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна

Цахим дэлгүүрт байршсан 6,139.8 мянган төгрөгийн ширээ, сандал, принтер зэрэг эд хогшил, тоног төхөөрөмжийг Үржих тэнгис ХХК, Бэст Компьютерс Технологи ХХК, Төгс барс ХХК зэрэг газруудаас худалдан авалтыг гүйцэтгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу ил тод нээлттэй зохион байгуулж, гүйцэтгэх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

"Мэдээлэл аудит" ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 23/50 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,266.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,367.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг үндэслэлгүйгээр олгосон зөрчилд төлбөрийн акт, шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй, төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 1,174.6 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн зөрчилд албан шаардлага, 4,724.2 мянган төгрөгийн төсөвт тусгагдаагүй зардал гаргаж илүү цагийн хөлсийг нэмэгдүүлэн олгосон зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,367.8	1	4,367.8	100.0
Албан шаардлага	2	1,174.6	2	1,174.6	100.0
Зөвлөмж	1	4,724.2	1	4,724.2	100.0
Нийт дүн	4	10,266.6	4	10,266.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан”** гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **1,982.0** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Л.Мөнхбатад 1,114.0 мянган төгрөг,
- Нярав Ч.Лхагважавт 868.0 мянган төгрөг

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нгтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **1,840.7** мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 1,282.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 558.1 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр 14 багшид тус бүр 15.0-20.0 хувиар тооцон, нийт 1,282.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухаан, Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Сангийн сайдуудын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35,А/10/2 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараа хувиар тогтооно”, “сургуулийн түвшинд 10 хувь” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс захирал Н.Бүрэнцогтод 558.1 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1.“Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусан илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг илүү бодож олгосон	1	1,282.6	1	1,282.6								
Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй	1	558.1			1	558.1						
Дүн	2	1,840.7	1	1,282.6	1	558.1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1						1	
Цахим дэлгүүрт байршсан барааг бусад газраас худалдан авсан	1	6,139.8					1	6,139.8
Дүн	2	6,139.8					2	6,139.8
Нийт дүн	3	6,139.8					3	6,139.8